


АЖ ТӨРӨХ
УХААН

Г.Ловор

ААВЫН АЧ ЭЭЖИЙН ЭРДЭМ



I
ангийнханд
зориулав

Г.Ловор
Аавын ач ээжийн эрдэм

Бага сургуулийн 1-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах Д.Сугархүү
Хянан тохиолдуулагч	О.Мөнхтуяа
Хянагч	Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Н.Хөдөлмөр Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК

2007 он

Аавын ач ээжийн эрдэм

Ээж,
Хоол унд бэлтгэхэд
Хольц тааруулахаа мэднэ.
Айраг цэгээ исгэхэд
Амт оруулахаа мэднэ.
Тогооч-ээжээрээ
Бахархана, би



Ээж,
Товч шилбэ ханзрахад
Торгоож хадахаа мэднэ.
Тохой өвдөг цоороход
Тааруулж нөхөхөө мэднэ.
Оёдолчин-ээжээрээ
Бахархана, би

Аав,
Уулгалам ороо адуунд
Уурга тогтоохоо мэднэ.
Уралдаанд давхих моринд
Уяа тааруулахаа мэднэ.
Адуучин-аваараа
Бахархана, би



Аав
Гэр, тэрэг сэлбэхэд
Эвийг нь олохоо мэднэ.
Авдар шүүгээ төхөөрөхөд
Аргыг нь олохоо мэднэ.
Дархан-аваараа
Бахархана, би

Аав,
Уурга яаж залгахыг
Надад заана.
Унь яаж өлгөхийг дүүд заана.
Багш-аавдаа
Баярлалаа, би



Ээж,
Утас яаж ээрэхийг
Дүүд заана.
Унд яаж бэлтгэхийг
Надад заана.
Багш-ээждээ
Баярлалаа, би




Бага сургуулийн 1-р ангийнханд зориулав.



Гэр бүлийн өдөр тутмын амьдралд хүүхэд идэвхтэй оролцож эдийн засгийн “Цагаан толгой”-д суралцана.



Гэр бүлийн хамтын хөдөлмөр хүний цаашдын амьдралын чухал сургууль болдог.



Гэр бүлийн хүрээнд аав, ээжийн эрхэлдэг ажил хөдөлмөр хүүхдэд аж төрөхийн хичээл болдог.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл”-ийн хүрээнд хэвлэв. Худалдахыг хориглоно.